


Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 4 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар 0°C (32°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +6°C (42.8°F) –аас +12°C (53.6°F), бусад нутгаар 0°C –аас +5°C (32°F –аас 41°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 4 дүгээр сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 3 хувьтай тэнцдэг. Тус сард Булган, Хөвсгөлийн зүүн хойд хэсгээр 10-17 мм, Ховд, Говь-Алтай болон нутгийн өмнөд хэсгээр 0.2-4.9 мм бусад нутгаар 5.0-10 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2026 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур ОЖД-аас 1.6°C-аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 10 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгаар дунджаас 1.1-ээс 5.4°C-аар дулаан байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 5.8 мм хур тунадас орсон нь ОЖД-аас 10.8%-иар бага бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 38 дахь бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 59.7% нь дунджаас бага, 34.1% нь ахиу, 6.2% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2026 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалт

Монгол орноор болон дөрвөн бүсээр хуваан дунджилсан 4 дүгээр сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) 1 болон 3 дугаар 10 хоногт нийт нутгаар ОЖД-аас дулаан байсан ба баруун, өмнөд бүсэд дунджаас 2-9.2°C-аар илүү дулаарсан байсан. Харин 2 дугаар 10 хоногийн дунд болон сүүл үед нийт нутгаар хүйтрэлт ажиглагдсан бөгөөд зүүн бүсэд температурын хэлбэлзэл их, богино хугацааны хүйтрэлтүүд үе үе давтагдсан байна. Хур тунадасны хувьд 1 дүгээр 10 хоногт ихэнх нутгаар, 2 дугаар 10 хоногт баруун, төв, зүүн бүс нутгаар, 3 дугаар 10 хоногийн сүүлд нутгаар харьцангуй ахиу хур тунадас тус тус орсон байна.



Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын аймгийн Шинэжинст суманд 29.0°C, үнэмлэхүй бага утга Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд -17.7°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Ховд аймгийн Булган суманд 54°C, үнэмлэхүй бага утга Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд -21°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Ховд аймгийн Ховд суманд 29-ний өдөр 15.7 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 954.6гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 762гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Говь-Алтай аймгийн Бугат суманд 38 м/с хүрчээ.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд